



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2016 оны 11 сарын 17-ны
өдөр хүлээн авсан.

МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 404

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад нэмэлт
оруулах тухай


1. Сангийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 333 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох журам"-ын 4 дүгээр зүйлд дараах агуулгатай хэсэг нэмсүгэй:

"4.6. Албан татвар төлөгч нь энэ журмын 4.2.2-т заасныг үл харгалзан тухайн хуанлийн жилийн сүүлийн өдрийн 24 цаг 00 минутаас өмнө худалдан авсан төлбөрийн баримтын мэдээллийг дараагийн хуанлийн жилийн эхний сарын 8-ны дотор бүртгүүлсэн байна."

2. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар (Ж.Ганбат), Төрийн сангийн газар (С.Наранцогт), Татварын ерөнхий газар (Л.Зориг)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

САЙД



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

САНГИЙН ЯАМНЫ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН

Бүртгэлийн №...
Төрийн захиргааны удирдлын газрын дарга

Архивын эрхлэгч
Нийт хуудас 20 17 сар 07 өдөр